

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД
НЭР ДЭВШИГЧ Ч.САЙНБИЛЭГ, С.ХАЛИУНАА НАРТАЙ ХИЙСЭН НЭР
ДЭВШИГЧИЙН СОНСГОЛЫН ТАЙЛАН**

Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн болон Хууль зүйн Байнгын хороо тус бүр хоёр хүний нэр дэвшүүлж, томилгооны сонсгол хийж Улсын Их Хурал томилохоор заасан бөгөөд тус хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т "Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг Улсын Их Хурлаас 3 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө." гэж, 29.4-т "Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, ажлын дадлага туршлагатай, ёс зүйн хувьд төлөвшсөн Монгол Улсын иргэнийг томилно." гэж заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-д "... Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн ... албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонсгол", 30.3-т "Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо явуулна.", 30.4-т "Нэр дэвшигчийн сонсгол явуулахад энэ хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг баримтална." гэж заасны дагуу нэр дэвшигчийн сонсголыг дараах үе шатаар бэлтгэн, зохион байгууллаа.

1.Хууль зүйн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хуралдаж Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 25-ны өдрийн хооронд бүртгэхээр тогтсон бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан болзол, шаардлагын хүрээнд Ч.Сайнбилэг, Л.Төр-Од, С.Халиунаа, З.Баянмөнх нарын нийт 4 иргэн Хууль зүйн байнгын хороонд материалаа ирүүлж, бүртгүүлсэн.

2.Хууль зүйн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр хуралдаж материалаа ирүүлсэн 4 хүнээр санал хураалт явуулж Ч.Сайнбилэг, С.Халиунаа нарыг хуульд тависан шаардлагыг хангасан гэж үзэж, олонхын саналаар дэмжиж, нэр дэвшигчийн сонсголд оролцуулахаар шийдвэрлэж, нэр дэвшигчийн мэдээллийг Parliament.mn Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан.

3.Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 27-ны 11 дүгээр тогтоолоор Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагч сонгох, сонсголын бэлтгэл хангахтай холбоотой дэг батлах тухай Байнгын хорооны тогтоолоор Сонсгол даргалагчаар Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатарыг томилж, нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулахаар тов тогтоосон бөгөөд нэр дэвшигчээс асуулт асуух, саналыг цахимаар авах, эсхүл шуудангаар хүлээн авах, сонсголд оролцох, ажиглах иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 15:00 цаг хүртэл авсан болно.

Дээрх хугацаанд сонсголд оролцогчоор нийт 3 иргэн оролцохоор бүртгүүлсэн бөгөөд ажиглагчаар оролцох болон нэр дэвшигчээс асуулт асуух иргэн, хуулийн этгээдийн хүсэлт ирүүлээгүй байна.

4.2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 12:00 цагт Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр ирц бүрдэж, нэр дэвшигчийн сонсголыг холбогдох хууль тогтоомжид заасан дэгийн дагуу явуулсан бөгөөд сонсголд Хууль зүйн байнгын хорооны гишүүн Дамдины Цогтбаатар, Жуковын Алдаржавхлан, Хүрэлбаатарын Баасанжаргал, Энхтайваны Бат-Амгалан, Дашдондогийн Ганбат, Батжаргалын Заяабал, Одсүрэнгийн Номинчимэг, Бөхчулууны Пүрэвдорж, Ухнаагийн Отгонбаяр, Гончигдоржийн Уянгахишиг, Пүрэвжавын Сайнзориг, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Даваагийн Цогтбаатар, Сүхбаатарын Эрдэнэболд нарын 15 гишүүд оролцлоо.

5.Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Чимэдийн Сайнбилэг, Соронзонболдын Халиунаа нарын товч танилцуулгыг Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулж, нэр дэвшигчид нэр дэвших болсон үндэслэл, эзэмшсэн мэргэжил, боловсрол, ажлын туршлагаа танилцуулсан.

5.1.НЭР ДЭВШИГЧ ЧИМЭДИЙН САЙНБИЛЭГ

Нэр дэвшигч нь нэр дэвших хүсэлтдээ нэр дэвшсэн үндэслэл, хийх ажлын талаар дурдахдаа: Монгол Улсын санхүү, эдийн засгийн орчин, зах зээлийн үйл ажиллагаа явуулах орчныг сайжруулах, нээлттэй, шударга, олон улсын хэм хэмжээг хэрэгжүүлэх талаар тусгасан байна.

Нэр дэвшигч Ч.Сайнбилэгээс Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, Б.Заяабал, О.Номинчимэг, П.Сайнзориг болон оролцогч Б.Ганбаяр нар асуулт асууж, хариулт авсан бол Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Г.Уянгахишиг нар үг нэр дэвшигчид хандаж үг хэллээ. Тухайлбал:

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал: Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс хөдөө орон нутгийн иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх болон орон нутгийн өмчит компани байгуулах замаар орон нутагтаа байгаа уул уурхай, ашигт малтмал, баялгаасаа хувь эзэмших нөөц бололцоог судалж, тодорхой шийдвэр гаргахад анхаарч ажиллах талаар;

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг: Хяналтын зөвлөл нь Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд нь хяналт тавьж, хөндлөнгийн хараат бусаар хяналт тавих чиг үүрэгтэй санхүүгийн зах зээлд нөлөө үзүүлэх чухал субъект тул томилогдсон тохиолдолд идэвхтэй, санаачилгатай ажиллах шаардлагатай талаар үг хэлсэн болно.

5.2.НЭР ДЭВШИГЧ СОРОНЗОНБОЛДЫН ХАЛИУНАА

Нэр дэвшигч нь нэр дэвших хүсэлтдээ нэр дэвшсэн үндэслэл, хийх ажлын талаар дурдахдаа:

1.Чөлөөт зах зээлтэй болсноос хойш Монгол Улсын компаниуд үндсэн капиталгаа зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж ирсэн бөгөөд банкны салбар санхүүгийн зах зээлийн 80-аас доошгүй хувийг эзэлж ирсэн. Хэдийгээр сүүлийн 8 жил үнэт цаасны зах зээл харьцангуй хөгжиж, Монголын томоохон компаниуд хөрөнгийн зах зээлээс санхүүжилтээ татаж байгаа ч банкны салбар санхүүгийн зах зээлд давамгайлсан хэвээр байна.

Хөрөнгө оруулагчдын зүгээс компанийн хувьцааны хөрөнгө оруулахаас илүүтэй банкны хадгаламжид илүү найдаж байгаа нь нэгт, хөрөнгө оруулагчид иргэдийн санхүүгийн боловсрол хангалтгүй байгаатай хоёрт, тухайн компанийн засаглал хангалтгүй, томоохон хувьцаа эзэмшигчид удирдлага төвлөрүүлсэн, ашиг сонирхлын зөрчил үүсгэдэгтэй шууд холбоотой. Нэн түрүүнд ашиг сонирхлын хэлцлийн ил тод байдлыг сайжруулснаар компанийн засаглал сайжирч, цаашлаад хувьцаа эзэмшигчдийн зүгээс тухайн компанид итгэх итгэл сайжирна.

Монгол Улсын компанийн тухай хуулийн дийлэнх зохицуулалт хувьцаат компанийн үйл ажиллагаа зохицуулж ирсэн бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй 150,000 гаруй аж ахуйн нэгжийн хувьцааг эргэлтэд оруулах зохицуулалт төдийлөн хангалтгүй байдаг.

2.Түүнчлэн ХХК-ийн эрсдэл даах, зээлжих чадварын гол үзүүлэлт болох хувь нийлүүлсэн хөрөнгө (дүрмийн сан)-ийг санхүүгийн тайлан, баланс дээр тусгах, хуулийн этгээдийн бие даасан байдал дийлэнх дунд болон жижиг компаниудад хэрэгжихгүй байна. Компаниуд санхүүжилт татахдаа хувьцаа эзэмшигчийн үл хөдлөх хөрөнгөөр батлан даалт гаргуулах эсвэл компанийн үйл ажиллагааны ашиг шимээс бий болсон хөрөнгийг хувьдаа өмчлөх зэрэг компаниуд хуулийн этгээдийн сонгодог зарчмыг хэрэгжүүлэхгүй байгаа нь компанийн засаглал хангалтгүй байгаа, цаашлаад хувьцааны санхүүжилт (equity finance) хөгжихгүй байгаагийн гол асуудал юм.

Equity finance буюу хувьцааны санхүүжилтийг хөгжүүлэх, хөрөнгө оруулагчдын "гарах төлөвлөгөө" буюу тухайн төсөл, компани нь өгөөжөө өгсний дараа хувьцаа дахин эргэлтэд оруулан гарах зохицуулалтыг Компанийн тухай хуульд нарийвчлан оруулснаар хөрөнгө оруулагчдыг эрх ашгийг хамгаалж, нэмэгдүүлэх. Ингэснээр нэгт, өртөг багатай санхүүжилтийг татаж компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг бууруулаад зогсохгүй компаниудын үйл ажиллагааг тэлж, шинээр ажлын байр нэмэгдүүлэх томоохон ач холбогдолтой.

3.Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу системийн нөлөө бүхий төдийгүй жижиг банкнууд ч хөрөнгийн бирж дээр хувьцаагаа арилжаалж эхэлснээр банкнуудын үйл ажиллагааг Монгол банк төдийгүй Санхүүгийн Зохицуулах Хорооны хяналтад үйл ажиллагаа явуулах болсон. Банкны үйл ажиллагаа, засаглал, тогтвортой байдал нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлын гол шалгуур болоод байна. Монгол Улс банк, банк бус санхүүгийн байгууллагын интернэт банк, финтек, гар утасны банкны үйлчилгээний чанар, хөгжлөөр бүс нутагтаа тэргүүлж байгаа. Финтек, цахим зээлийн үйлчилгээ нь нэг талдаа Банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны өртгийг бууруулж, нөгөө талдаа иргэдийн санхүүгийн бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлж байна. Үүний үр дүнд 2-р улирлын эцсийн байдлаар банк, ББСБ-ын иргэдийн зээлийн эзлэх хувь нийт зээлийн 14.7% ББСБ буюу нийт зээлийн үлдэгдэл 27.8 их наяд төгрөг хүрээд байна.

4.Нөгөөтээгүүр үйл ажиллагаа нь харьцангуй өндөр хяналтад байдаг банкнуудын өр орлогын харьцаа 50.4% байхад ББСБ-д өр орлогын харьцаа 80 хувь, чанаргүй зээлийн харьцаа банкнуудад 2.6%, ББСБ-уудад 5.9% тус тус байгаа нь богино хугацаандаа ББСБ-уудын эрсдэлийн удирдлага хангалтгүй байдлаас болж санхүүгийн зах зээлд тогтворгүй байдлын эх үүсвэр болох талаар тусгажээ.

Нэр дэвшигч С.Халиунаагаас Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, П.Сайнзориг, О.Номинчимэг болон оролцогч Б.Ганбаяр нар асуулт асууж, хариулт

авсан бол Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, С.Эрдэнэболд нар нэр дэвшигчид хандан үг хэлсэн болно. Тухайлбал:

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал: Өмнө нь нэр дэвшигч С.Халиунаатай хамтарч ажиллаж байсан бөгөөд хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй талаар, мөн Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс хөдөө орон нутгийн иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх болон орон нутгийн өмчит компани байгуулах замаар орон нутагтаа байгаа уул уурхай, ашигт малтмал, баялгаасаа хувь эзэмших нөөц бололцоог судалж, тодорхой шийдвэр гаргахад анхаарч ажиллах талаар;

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд: Өмчийн эрхийн асуудалд бэлтгэгдсэн хүн Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгааг дэмжиж байгаа бөгөөд санхүүгийн зах зээлийн салбарыг ил тод, логиктой, хариуцлагатай байлгах тал дээр анхаарч ажиллах шаардлагын талаар үг хэлсэн.

Хууль зүйн байнгын хорооны дарга **Дамдины Цогтбаатар** нэр дэвшигчидтэй холбогдуулан Монгол Улсын хөрөнгийн зах зээлд 20 хүртэлх сая долларын хөрөнгө оруулалтыг гаднаас гуйгаад байх биш Монголдоо зөв бизнес моделио гаргаад хөрөнгө оруулалтаа босгоод явах бололцоотой болсон бөгөөд энэ цаг үед санхүүгийн зах зээл, үнэт цаасны арилжаанд оролцогчдын харилцааг зохицуулах, хяналт тавих тогтолцоог сайжруулах, үнэт цаасны арилжаанд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, аюулгүй байдлыг хангасан хууль эрх зүйн орчноо бүрдүүлэх шаардлагын талаар үг хэлсэн болно.


6. Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнийг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу Хууль зүйн байнгын хороо нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор буюу 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргасан.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нэр дэвшигч Ч.Сайнбилэг, С.Халиунаа нарыг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүний хуульд заасан болзол, шалгуурыг хангаж байгаа тул Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар эцэслэн шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

СОНСГОЛ ДАРГАЛАГЧ:

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Д.ЦОГТБААТАР

ТАНИЛЦУУЛГА

/Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч/



1.Овог нэр:

Чимэд Сайнбилэг

2.Хэзээ, хаана төрсөн:

1975 онд Дархан хотод төрсөн

3. Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн мэргэжил, эрдмийн зэрэг, цол:

- 1993-1997 онд МУИС-ийн Эдийн засгийн дээд сургуулийг Эдийн засагч, бакалавр
- 2006-2008 онд АНУ-ын California International University Олон улсын бизнесийн шинжлэх ухааны магистр

4. Ажилласан байдал:

- 1997-2008 онд Монгол шуудан банканд Дилер
- 2013-2016 онд Хадгаламжийн даатгал корпорацийн Дэд захирал
- 2017-2020 онд Тээвэр хөгжлийн банканд Санхүү эрхэлсэн захирал

ТАНИЛЦУУЛГА

/Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч/



1.Овог нэр:

Соронзонболд Халиунаа

2.Хэзээ, хаана төрсөн:

1983 онд ОХУ-ын Краснодар хот

3. Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн мэргэжил, эрдмийн зэрэг, цол:

- 2001-2005 онд МУИС-ийн Гадаад хэл соёлын сургуулийг Орчуулагч, бакалавр
- 2004-2008 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Эрх зүйч, бакалавр
- 2020 онд Англи улсын Cardiff Metropolitan University Бизнесийн удирдлагын магистр

4. Ажилласан байдал:

- 2013-2014 онд Хүүхдийн төлөө үндэсний газарт Хуулийн зөвлөх
- 2014-2016 онд “АПУ” ХХК-ийн Хуулийн зөвлөх
- 2016-2020 онд “Ард санхүүгийн нэгдэл” ХХК-ийн Хууль дүрмийн нийцэл хариуцсан захирал
- 2020-2021 онд “Скайтел” ХХК-ийн Хуулийн зөвлөх
- 2021 оноос “Грандлекс партнерс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

---ooOoo---